

# ЯДУУРЛЫН УЧИР ШАЛТГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

*Я.Бямбасүрэн  
Төрийн удирдлагын доктор (Ph.D)*

Өнөөдөр монгол улсын хүн амын 36.1<sup>1</sup> хувь нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур амьдралтай байна. Энэ нь ядуурал нийгмийг хамарсан үзэгдэл болоод байгааг гэрчилнэ. Ядуу амьдралтай иргэдийн нийт хүн амд эзлэх хувь 1998 онд 35.6, харин 2002 онд 36.1 хувь байжээ. Гэвч энэ үзүүлэлт өнөөг хүртэл буураагүй байгаа нь бидний өнгөрсөн жилүүдэд авч явуулсан бодлого, хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрээгүйг харуулж байна. Одоо ядуурлаас яаж гарах вэ гэдэг асуудал төр засаг, ард иргэд, хэн бүхний тулгамдсан асуудал болсоор. Ядуурлыг гэтлэн давахын тулд асуудлын мөн чанарыг олж, түүнийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь чухал юм.

Ядуурал гэдэг нь орлогын болон ур чадварын хомсдол, харилцааны ганцаардал зэргээс үүдэн тухайн иргэн нийгмийн хэвийн түвшингээс доогуур байр суурьтай болох үзэгдэл юм (Кит Грифин, 27). Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэд өөрийн амьжиргааг залгуулахын тулд бусдаас хараат болдог. Ядууралд орсон иргэдийн ядуурлын замналыг авч үзвэл дээрх гурван хүчин зүйлийн аль нэгэн нь анхдагч болсон тохиолдол байгаа ч манай орны хувьд орлогын хомсдолоос үүдсэн ядуурал зонхилох шинжтэй байна

Өмнө хийгдэж байсан судалгаанууд нь ихэвчлэн ядуурлыг хэмжих, ядуурлын хамралтыг тогтооход чиглэгдэж иржээ. Эдгээр судалгаанд ядуурлын түвшинг хэрхэн тодорхойлох болон ядуу хүмүүсийн боловсрол, эрүүл мэнд, хэрэглээний байдлыг ядуу бус хүмүүсийнхтэй харьцуулан судалгааны тайланг боловсруулжээ. Энэ судалгаануудын тайлан нь ядуурлын учир шалтгааны талаар биш, харин түүний шинж тэмдгийн талаар түлхүү мэдээлэл агуулж байна. Гэтэл ядуурлыг бууруулах, улмаар арилгахын тулд үндсэн шалтгаан, ядууралд хүргэж буй хүчин зүйлсийг олж тогтоох нь чухал юм. Бид шинж тэмдгийг арилгах үйл ажиллагаа явуулаад амжилтанд хүрэхгүй гэдгийг өмнөх бодлогын хэрэгжилтүүд нэгэнт нотлон харуулж байгаа билээ.

Ядуурлын хамралт өндөр байгаагийн учир шалтгааныг нийгмийн сэтгэл зүйн өөрчлөлт, бодлогын алдаа, хувь хүний хоцрогдол гэсэн гурван үндсэн бүлэгт хуваан авч үзэж болно. Нийгмийн сэтгэл зүйн өөрчлөлт нь өмнөх үеийн сэтгэлгээний үлдэгдэл, “өнөөдрөөр баримжаалсан улс төрч” - дийн үйлдлээр бий болж, ядуу иргэдийн хүлээлт бий болгодог. Бодлогын алдаа нь бодлогын зорилго, зорилтыг ядуурлын шинж тэмдгийг арилгахад чиглүүлэн тодорхойлсон нь гажуудлыг үүсгэж, улмаар ядуурлын хамралт байнга өсөн нэмэгдэхэд нөлөөлж байна. Харин хувь хүний хоцрогдол нь нийгмийн өөрчлөлтийг үл мэдрэн өөрийгөө хөгжүүлэх, оршин байх нөхцөлөө дээшлүүлэх талаар ажиллаж чадаагүйтэй холбоотой хүчин зүйлс юм.

## **Нийгмийн сэтгэл зүйн өөрчлөлт**

Төрөөс бүх зүйлийг хангах ёстой гэсэн социализмийн үеийн нийгмээр тэтгүүлэх сэтгэлзүй одоо болтол ядуу хүмүүсийн хувьд өөрчлөгдөөгүй бөгөөд төрөөс хангана гэдэг ойлголтын оронд ямар нэгэн улс төрийн хүчин хангана гэсэн ойлголт тэдний дунд хүрээгээ тэлж байна. Энэ байдал нь сонгуулийг арилжааны хэлбэрт оруулах аюулыг бий болгодог. Үүний зэрэгцээ нийгмийн томоохон хэсэг ядуу байгаа нь улс төрчдөд санал худалдан авах боломжийг бий болгож байгаагийн дээр эргээд улс төрчөөс хүсэх тэтгэлэгийн талаарх хүлээлтийг өндөр болгож байна. Энэ өндөр хүлээлтийг улс төрийн сонгуулийн санал авахын тулд сонгогчдыг бараа, бэлэн мөнгөөр татах, нэг удаагийн тэтгэмж өгөх зэргээр улам ихэсгэж, ингэснээрээ саналын мөнгөн илэрхийлэл бий болдог. Энэ нь ядуу

---

12004 оны урьдчилсан үнэлгээ, [www.cia.gov/cia/publications/factbook/geos/mg.html](http://www.cia.gov/cia/publications/factbook/geos/mg.html) сайтаас 2005 оны 04-р сарын 30 өдөр татсан

иргэдийн нийгмээр тэтгүүлэх сэтгэлгээг цэцэглүүлэн хөгжүүлж байна. үүнийг гол өдөөгч нь “өнөөдрөөр баримжаалсан улс төр” юм.

Өнөөдрөөр баримжаалсан улс төр гэдэг нь ирээдүйд үтээх баялгийн тухай биш өнөөдөр байгаа баялгийг хэрхэн хүртээмжтэй хуваах тухай ярьж, бичиж буй улс төрийн өйл ажиллагаа юм. Өнөөдрөөр баримжаалсан улс төр нь төр барьж байгаа нам нийгмийн баялгийг буруу хуваарилж байгаа талаарх хардлага, буруутай нь тогтоогддоггүй авилгалын хэрэг, хэрэв төр баривал хэрхэн шударгаар хуваах тухай үлгэр, төрийг амтат бялуу хэмээн үзэх үзэл зэрэг хэлбэрээр нийгэмд илэрч, ядуу хүмүүсийн хомсдолын аж байдал дээр тоглолт хийж, төрийн эрх мэдлийг авах тэмцэл болон явагдаж байна. Энэ байдал нь миний ядуу байгаад төр 100 хувийн буруутай гэсэн итгэл үнэмшлийг ядуу иргэдэд өгч, нийгэмд шударгаар баялаг бүтээгчийг үзэн ядах үзлийг дэвэргэж, хөнгөн хялбар амьдрах хий горьдлого, найдлагыг түгээн дэлгэрүүлж байгаа юм.

### **Ядуурлыг бууруулах бодлогын алдаа**

Өнөөг хүртэл хэрэгжиж ирсэн төрийн бодлогыг, хэрэгжүүлж буй аргын нь хувьд “өрөвдөх” болон “найдлага” төрүүлэх гэж ангилж болно. Өрөвдөх бодлого гэдгийг ядуу хүмүүсийг амьд байлгахын тулд төдий хэмжээний хөрөнгө хэрэгтэй байна үүнийг зээл тусламж, улсын төсвөөс хангана гэсэн ерөнхий зорилтын дор хийгдэж буй бүх үйл ажиллагааг хамруулан ойлгож болно. Найдлага төрүүлэх бодлого гэдэг нь төрөөс ядуурлыг бууруулах, тэдэнд тусламж үзүүлэх тухай шийдвэрийг хөрөнгийн эх үүсвэргүйгээр батлан гаргах, мөн хаа нэг газар ядуучуудад үзүүлсэн тусламж үйлчилгээг удахгүй бүх ядуу иргэдэд үзүүлэх мэтээр нийгэмд мэдээлэх зэргээр “тусламж хаа нэгтэйгээс ирнэ” гэсэн найдлага төрүүлж байгаа үйл ажиллагаа юм.

1995, 1996, 2000 онд ядуурлыг бууруулах чиглэлээр төрөөс хэд хэдэн бодлогын баримт бичиг боловсруулж түүнийг хэрэгжүүлсэн байна. Эдгээр баримт бичгүүдэд өрөвдөх бодлогын чиглэлийн зорилтууд нь илүү тодорхой тусгагдаж, харин хүнийг хөгжүүлэх чиглэлийн зорилтуудыг туйлын ерөнхий байдлаар тодорхойлжээ. Жишээлбэл *1. Халамжийн төвүүдийг түшиглүүлэн орон гэргүй нэн ядуу хүмүүсийг хоноглуулах, хооллох байр бий болгож, нийгмийн халамжийн сан болон буяны байгууллагын хандивын оролцоотой санхүүжүүлнэ.* Энэ бол маш тодорхой зорилт байна. Гэтэл хамгийн чухал нь болох ирээдүйн ядуурлаас гаргах зорилт дараах байдлаар ерөнхий тодорхойлогдсон байна. Тухайлбал *2. Бүтэн өнчин болон тэнэмэл хүүхдийг халамжлах тэдэнд боловсрол, хүмүүжил, хөдөлмөрийн дадлага олгох нөхцөлийг бүрдүүлнэ.* Нөгөө талаар ядуу иргэдийг ажлын байртай болгох чиглэлээр хөрөнгө оруулалт хийсэн иргэд, аж ахуйн нэгжийг дэмжих бодлогын талаарх зорилт байхгүй зөвхөн төр л бүх зүйлийг хийх мэтээр тодорхойлогдсон байна. Өрөвдөх бодлогын үр дагавар нь нийгэмд дараах сөрөг итгэл үнэмшлийг түгээн дэлгэрүүлж байна. Үүнд:

- Ядуу байвал хоол, хувцас болон бусад зүйлээр хангана
- Ядуучуудыг тэтгэх нь төрийн нэн тэргүүний үүрэг мөн
- Ядуу байх нь цаг наргүй хөдөлмөрлөснөөс дээр
- Ядуугаа хэдий хэмжээнд сайн нотолж чадна, төдий хэмжээнд тэтгэмж авах боломжтой

Ийм итгэл үнэмшил нийгэмд хүрээгээ тэлж бэхжиж байгаа нь ядуугийн бүртгэлд хамрагдах талаар өрсөлдөөнийг бий болгож байгаа бөгөөд хэрэв төрөөс одоогийн олгож байгаа тэтгэмж болон бусад дэмжлэгийг нэмэгдүүлэх юм бол дундаас доогуур амьдралтай иргэдийн тоо өндөр байгаа нөхцөлд ядуугийн бүртгэлд орох талаар авилгалын асуудал ч үүсэхийг үгүйсгэх аргагүй юм. Иймд өрөвдөх бодлогыг өөрчилж ядуурлаас гарахыг эрмэлзэж буй иргэдэд чиглэсэн дэмжих бодлого хэрэгтэй байна.

Найдлага төрүүлэх бодлого нь ихэвчлэн төрийн өндөр албан тушаалтны бодит нөхцөл байдлыг ухаараагүй хэт улс төржсөн мэдэгдэл, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэлгүйгээр баталсан хөтөлбөр, төсөл зэргээс үүдэн бий болдог. Үүний жишээнд цагаан, ногоон хувьсгал хөтөлбөр, мянганы замын бүтээн байгуулалтын талаарх буруу ташаа мэдээлэл зэргийг оруулж болно. Мянганы зам хөтөлбөр нь иргэдийг ажлын байртай болгох чиглэлд томоохон ахиц авчирна гэсэн

мэдээг нийгэмд цацсан боловч энэ нь өөр чиглэлээр хөгжиж байгааг хэн бүхэн харж байна. Нөгөө талаар өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлэх амлалт, хүүхдийн 3000 төгрөгийн тэтгэмжийг ч мөн дурьдаж болно. Найдлага төрүүлэх бодлого нийгэмд дараах үр дагаврыг авчирч байна. Үүнд:

- Ядуучуудад дэмжлэг үзүүлэх тодорхой нөөц төрд байна, харин төр засаг түүнийг өгөхгүй байна
- Төрд итгэх итгэл алдрах
- Ямар нэгэн аргаар төрийн албанд орж, тэр нөөцөөс хүртэх
- Хэн нэгэн нь ядуу хүний амьдрал ахуйг нь өөд татах хариуцлага хүлээж байгаа мэт хий найдлагыг төлөвшүүлж байна

Эдгээр нь өнөөгийн ядуу хүмүүсийг байгаагаараа байхад болно гэсэн итгэл үнэмшлийг төрүүлж, ажил бага хийж, дутагдах гачигдах юмгүй амьдарч болно гэсэн гэнэн мөрөөдөлд хөтлөгдөн өдөр хоног өнгөрөөх сэтгэл зүйг бий болгодог. Нөгөө талаар энэ гэнэн мөрөөдөл дээр нь тулгуурлан ашиг хонжоо эрэгч бүлэг хүмүүсийг бий болгоод байна. Жишээлбэл бүх төрлийн сүлжээний бизнес, өндөр ашигтай бизнес саналууд зэргийг нэрлэж болох юм. Төрийн найдлага төрүүлэх бодлогын үр дүнд нийгмийн далд бухимдал, ядуурал улам бүр нэмэгдэж байна.

Төрийн бодлогын алдаа нь ядуурлыг улам гүнзгийрүүлж, түүгээр бизнес хийх сонирхлыг нийгмийн тодорхой хэсгийнхэнд олгож, баялгийн тэгш бус хуваарилалтыг улам бүр нэмэгдүүлж байна. Төр өөрийн энэ бодлогын гажуудлыг залруулахгүй бол иргэдийн хүнийрхэх үзэгдэл хүрээгээ тэлж, ирээдүйдээ итгэх итгэл алдарч, дарангуйлагч гарч ирэх түүхэн нөхцөлийг ч бий болгохыг үгүйсгэх аргагүй юм.

### **Хувь хүний хоцрогдол**

Төрийн бодлогын алдаа, улс төрийн орчны сөрөг нөлөөллөөс гадна хувь хүний хоцрогдол нь ядуурлыг үүсгэгч нэг гол хүчин зүйл болдог байна. Мэдлэгийн болон мэдээллийн хоцрогдол, дасан зохицох, бэрхшээлийг гэтлэн давах чадварын хомсдол, эдийг зөв зарцуулах аргын дорой байдал зэргээс үүдэн хүмүүс ядуурч байна.

Мэдлэг, мэдээллийн хоцрогдол нь хүнийг нийгэмтэйгээ зэрэгцэн хөгжих боломжийг хааж, улмаар орлогын хомсдолыг бий болгон ядууралд хүргэж байна (Кит Грифин, 29). Ядуу хүмүүсийн хувьд өмнөх нийгмийн үед эзэмшсэн мэдлэг аль хэдийн хуучирсан, мэдээллийн гол сувгуудаас алслагдсан зөвхөн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээ, мэдээллийг хүлээн авч байгаа зэрэг нь хоцрогдлын үндсэн шалтгаан юм. Нөгөө талаас удаан хугацаагаар ажилгүй байх, өөрийгөө хөгжүүлэх талаар санаачлагагүй байх, өөрийн эзэмшсэн мэргэжлийн бүлгийн харилцаанд оролцохгүй байх зэрэг нь мэдлэг мэдээллийн хоцрогдлыг үүсгэдэг. Нэгэнт тухайн үйл явцын талаар нарийвчилсан мэдээлэлгүй, хэдийгээр мэдээлэлтэй байсан ч түүнийг задлан шинжлэх, хэрэглэх мэдлэггүй байгаа нь шийдвэрийн хожидлыг үүсгэн, алхам бүртээ алдагдал хүлээх нөхцөлийг бүрдүүлж байна. Өнөөдрийн мэдээллийн тархац өндөр хурдтай байгаа нөхцөлд үүнээс үүдэх алдагдал маш өндөр билээ. Мэдлэгийн хоцрогдол үүссэн тохиолдолд ядуу хүн өөрөө ядуурлаас гарах арга зам бараг байхгүй юм.

Мэдлэг, мэдээллийн хоцрогдол нь ядуу хүнд дараах сөрөг үр дагаврыг бий болгодог. Үүнд:

- Өөртөө итгэлгүй болох, айдаст баригдах
- Бусдын хараат болох
- Орлогын байнгын хомсдолд орох
- Таамаг мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах
- Хөдөлмөрийн зах зээлд эрэлтгүй болох

Энэ үр дагаврууд нь улам ядуурч уруудах шургийн хүчин зүйлийг бий болгож байна.

Хэдийгээр мэдлэг, мэдээлэлтэй боловч нийгмийн өөрчлөлтөнд дасан зохицох, тулгамдсан бэрхшээлийг гэтлэн давах чадварын хомсдолоос болж ядуурах тохиолдол байдаг (Ц. Далай нар, 53). Дасан зохицох чадварын хомсдол нь урьдын сайхан цагийн тухай дурсамж байдлаар илэрч, өнөөдрийн ядууралд хэн нэгэн буруутанг эрж хайх байдлаар даамжран, өөр хэн нэгэн буянтан ядуурлаас гаргах тухай гэнэн мөрөөдөл болж үргэлжилдэг. Дасан зохицох чадварын хомсдолыг бий

болгож байгаа үндсэн хүчин зүйл бол найдлага төрүүлэх бодлого, үнэнийг нуун дарагдуулсан мэдээлэл, харилцааны алдагдал, шийдвэр гаргах эрх мэдлийг зөв цаг хугацаанд олгоогүй гэр бүлийн хүмүүжлийн алдаа дутагдал, нийгмээс хэт таслагдсан амьдралын хэв маяг зэрэг юм.

Дасан зохицох чадварын хомсдол нь хүмүүсийн амьдралд дараах сөрөг үр дагаврыг бий болгож байна. Үүнд

- Нийгэм, орчин тойрондоо гомдоллох, буруутан этгээдэд өсөрхөх, түүнийг шийтгэх
- Гэр бүлийн уур амьсгалыг бусниулах
- Бусдын тусламжийг тасралтгүй хүсэж орлогын хомсдолд орох
- Хувь заяандаа найдах, мухар сүсэгт автах

Энэ үр дагаврууд нь байнгын ядууралд байх сэтгэл зүйн урьдач нөхцөлийг бий болгож байна. Түүнчлэн энэ байдал удаан үргэлжилбэл мэдлэг, мэдээллийн хомсдолыг бий болгож доошлох шургийн үйлчлэлд орох болно.

Мөн өөрт байгаа эдийг зөв зарцуулах аргын дорой байдлаас үүдэн ядуурах буюу ядуурлаас гаргах талаар дэмжлэг үзүүлсэн ч гаргахгүй байх тохиолдол цөөнгүй байна. Эдийг зөв зарцуулах аргын дорой байдал нь өнөөдрөөр баримжаалан амьдрах хэв шинжтэй хүмүүс, мансуурах, архидах болон бусад зохистой амьдралын арга ухаан эзэмшээгүй хүмүүст элбэг тохиолддог. Эдийг зөв зарцуулах аргын дорой байдал нь өрөвдөх бодлого, бэлэнчлэх сэтгэлгээ, амьдралын буруу зуршил, мэдлэг мэдээллийн хомсдол, “чөлөөт орлого” зэрэг хүчин зүйлээс үүдэн бий болдог.

Эдийг зөв зарцуулах аргын хомсдол нь дараах сөрөг үр дагаврыг бий болгож байна. Үүнд

- Баялаг бүтээхийн мөн чанарыг ойлгохгүй болох
- Хялбар аргаар амьдрах арга замыг хайж хий найдах
- Орлогын хомсдолд байнга орох
- Нийгэмд сөрөг үзэгдлийг дэлгэрүүлэх

Эдгээр үр дагавар нь нийгэмд байнгын ядуу давхаргыг төлөвшүүлэх, гэмт хэргийн сүлжээг бий болгох, нийгмийн аюулгүй байдлын хамгаалалтын зардлыг өсгөх зэрэг дагалдах үр дагавруудыг бий болгоно.

Хувь хүнийг ядууралд хүргэж байгаа эдгээр хүчин зүйлс тус бүрийг арилгахад тусгайлсан бодлогын хөтөлбөр гаргах нь төдийлөн ач холбогдолгүй байж болно. Ядууралд орсон хүн өөрөө тэр байдлаасаа гарах арга замыг бий болгох нь маш их цаг, хөрөнгө шаардсан ажил юм. Харин цогцолбор арга хэмжээг бий болгох шаардлагатай байна. Иймд ядуурлаас гаргахад нийгмийн баялгийг бүтээгч хүчний дэмжлэг маш чухал болно. Бодлогын ерөнхий чиг хандлага баялаг бүтээгчдээс ядуурлыг бууруулах талаар хийж байгаа үйл ажиллагааг урамшуулахаас эхлэх нь зүйтэй. Энэ үед л ядуурлыг бууруулах үйл ажиллагааны үр дүн харагдах болно.

### Дүгнэлт

Монгол орны ядуурлыг үүсгэгч хүчин зүйл нь өнөөдрөөр баримжаалсан үлс төрчдийн хөгжүүлж буй нийгмээр тэтгүүлэх сэтгэлзүйн хүлээлт, зорилго зорилтын алдаанаас үүдэлтэй бодлогын алдаа, мөн хувь хүний өөрийн идэвх санаачлагатай холбоотой хоцрогдол зэрэг болно. Эдгээр хүчин зүйлс нь ядуу хүнийг улам ядууруулах замаар доошлох шургийн үйлчлэлийг бий болгож байна. Доошлох шургийн үйлчлэлийг зогсооход нийгмийн баялаг бүтээгч бүтээлч хүчийг ашиглахгүйгээр зөвхөн төрийн шууд тэтгэлэгээр ядуу хүмүүс өөрөө энэ байдлаасаа гарна гэвэл маш их цаг хугацаа, өртөг шаардсан үйл ажиллагаа болно. Ядуурлыг бий болгож байгаа аль нэг хүчин зүйлийг дангаар нь шийдвэрлэх боломжгүй бөгөөд хүчин зүйл тус бүрийг нь нарийвчлан судлах, уялдаа холбоог нь цогц байдлаар авч үзэх шаардлагатай. Нарийвчилсан судалгаа хийсний үндсэн дээр асуудлыг цогцолбороор шийдвэрлэх бодлого гарган нийгэм хамтаараа тэмцэж ядуурлыг бууруулах боломжтой.

**Ашигласан материал:**

1. Кит Грифин нар, Хөгжлийн стратегид ядуурлыг бууруулах асуудлыг тусгах сэдэвт семинарын баримт бичиг УБ. 2001
2. Статистикийн эмхтгэл 2002, ҮСГ., УБ
3. Ц. Далай, Л Оюунцэцэг, Дунд орлоготой хүмүүсийг эмзэг бүлгийн эгнээнд орохоос урьдчилан сэргийлэх арга замууд судалгааны тайлан, УБ. 2004 он
4. Б. Батмөнх, Г.Уранчимэг Хөдөлмөр эрхлэлтийн салбарт зарцуулж буй улсын төсвийн хөрөнгөнд хийсэн жендерийн дүн шинжилгээ судалгааны тайлан УБ. 2004
5. Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгааны үндсэн тайлан, ред. П.Бямбацэрэн, Р. Ойдовданзан, ҮСГ, УБ., 2004